

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 3 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 3-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1070 болж, 2013 оны мөн үеэс 370 хүнээр, өмнөх сарынхаас 80 хүнээр тус тус буурав.

Ажилгүйчүүдийн 52,24 хувь буюу 559 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 356 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 96 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 32,29 хувь буюу 31 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 3 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 52 ажилгүй иргэний 34,6 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан, 17,3 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон, 15,4 хувь нь өөр газраас шилжин ирсэн, 15,4 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих хүсэлтэйбайгаа, 3,8 хувь нь гүйцэтгэж

буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон, 3,8 хувь нь цэргээс халагдсан, 1,9 хувь нь байгууллага татан буугдсан, 1,9 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 5,8 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 21,87% нь дээд; 10,56% нь тусгай дунд; 10,75% нь мэргэжлийн анхан шатны; 37,48% нь бүрэн дунд; 15,23% нь бүрэн бус дунд боловсролтой; 4,11% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ


*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 3 сард НДШ-ийн орлого 3089.7 сая ₮ болж төлөвлөгөө 86.0 хувь болж, төлөвлөгөөг Борнуур сум 103.7 хувиар биелүүлж, бусад сум 10.2-19.5 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 154.5 сая ₮ болж төлөвлөгөө 100.7 хувиар бүх сум давуулан биелүүллээ. Тэтгэвэр, тэтгэмжинд 1376,6 сая ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.0 хувийг өндөр настны, 11.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 6.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 339.685 ₮ боллоо. Нийгмийн даатгалын нийт зарлагын 38.6% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 27.8%; тэтгэмжийн даатгалын сангийн 109.8%; эрүүл мэндийн даатгалын сангийн 99.4%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 149.4%; ажилгүйдлийн даатгалын сангийн 135.4%-ийг тус бүр бүрдүүлжээ.



Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 3 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 70824 хүнд олгож, 3415.1 сая ₮-ийг зарцуулж 2013 оны мөн

үеэс хүний тоо 75.5 хувь 30483 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 59.9 хувь 1280.6 сая ₮-өөр өслөө.


Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 100160 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.25 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 19.70 хувийг халамжийн тэтгэвэр; 7.13 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 4.03 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.54 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 2.50 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.76 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 3 сард 4429 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчвөнд дунджаар 7.8 ор хоног ноогдлоо. Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 3 сард 339 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 64 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 3 сард нялхсын эндэгдэл 1 хүүхэд гарч

өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхэд буюу 50 хувиар буурлаа.

1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл 2014 оны 3 дүгээр сард 1 болсон бол өмнөх оны мөн үед 2 байжээ.


Зураг I.4



2014 оны эхний 3 сард нийт гарсан халдварт өвчнөөр 113 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 34.6 хувь буюу 60 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 1 дахин, заг хүйтэн 7,6 хувиар тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 13 байгаа бол: Зуунмод 38, Мөнгөнморьт 25, Заамар 25, Баян-Өнжүүл 25, Сүмбэр 22 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



I.4 Байгаль орчин

Төв аймгийн 2014 оны 3-р сарын цаг агаарын байдлыг олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур 3-7 градус хүйтэн буюу Цээл, Заамар болон нутгийн баруун өмнөд хэсгээр дулаан, нутгийн зүүн хэсэг, Алтанбулаг, Мөнгөнморьт, Эрдэнэ орчмоор хүйтэн

- өдрийн агаарын хамгийн дулаан температур +11-+16 градус дулаан, Эрдэнэ болон нутгийн зүүн хэсгээр хүйтэвтэр, Лүн, Өндөрширээт болон баруун өмнөд хэсгээр дулаавтар байна.

- шөнийн хугацааны хамгийн хүйтэн температур нь 20-30 градус хүйтэн, Заамар, нутгийн баруун хэсгээр дулаавтар, Мааньт, Эрдэнэ, Батсүмбэр, зүүн хэсэг, голын хөндийгөөр 28-30 градус буюу хамгийн хүйтэн байв.

- бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0.0-4,7 мм буюу ихэнх нутгаар бага цас оржээ. Хамгийн их нь Батсүмбэрт 4.7 мм, Дэлгэрхаанд 4,3 мм, Лүн орчмоор 3.7 мм, Борнуурт 2,9 мм цас орж, харин Бүрэн, Баян-Өнжүүл, Баянцагаан нутгийн зүүн болон өмнөд хэсгээр бага хур тунадас оржээ.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

- агаарын дундаж температур нь нийт нутгаар 1-3 градусаар дулаан буюу ойролцоо

- өдрийн хамгийн их температур ихэнх нутгаар 1-4 градусаар дулаан буюу ойролцоо

- шөнийн хамгийн бага температур ихэнх нутгаар ойролцоо буюу 1-6 градусаар дулаан, нутгийн баруун хойд, өмнөд хэсгээр 1-5 градусаар хүйтэн

- сум тус бүрээр гаргасан хур тунадасны нийлбэр ихэнх нутгаар ойролцоо, Бүрэн, Баянцагаан, Баян-Өнжүүл нутгийн зүүн,

өмнөд хэсгээр 1-9 мм-ээр бага цас оржээ.

- салхи 9-14 м/с, ихэнх нутгаар 16-18 м/с, түр зуур 20-24 м/с хүрч зарим газраар цасан болон шороон шуурга, цас орох үеэр явган шуурга ажиглагдав.

2014 оны 3-р сар нь өмнөх оны тухайн сараас дулаан байсан нь агаарын температураас харагдаж байна. 3-р арав хоногт ихэнх нутгаар цасгүй, зарим сумдаар 0-1 см байгаа нь өмнөх оноос цас багатай, мөн гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи шуурга

2014 оны 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Энэ сарын агаарын дундаж температур нь аймгийн зүүн хэсгээр 5-9, бусад хэсгээр 10-15 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь аймгийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2014 оны эхний 3 сард 8 удаа гарсны улмаас 1 хүн амь насаа алдаж, 1 толгой мал хорогдлоо. Энэ оны 3 сард объектын түймэр 8 удаа, шатсан гэр, орон сууц 2 удаа бүртгэгдлээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2014 оны эхний 3 сард 582.1 сая ₮-ийн хохирол учирлаа.

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 3 сарын байдлаар*

Үзүүлэлт	2013 III	2014 III	2014 III / 2013 III %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	31	8	25.8%
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо		1	
Шатсан гэр, орон сууцны тоо	7	2	28.6%
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, мян.тол	3	1	33.3%
Объектын түймрийн тоо	13	8	61.5%
Учирсан хохирлын хэмжээ, сая ₮	212.8	582.1	273.5%

Тайлбар: *- Онцгой байдлын газрын мэдээ




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 3 сард аймгийн хэмжээнд 238 гэмт хэрэг бүртгэгдэж 175 хүн холбогдож төр, иргэдийн 720.2 сая ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 3 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 43.7 хувь нь хулгай, 25.56 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 10.5 хувь нь бусад хэрэг. 15.1 хувь нь замын осол, 3.8 хувь нь танхай дээрэм, 1.3 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Архуст, Угтаал, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баян-Өнжүүл сумдад 10000 хүнд 172-50 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (27) харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 52 хэргээр өслөө.

Зуунмод суманд 16, эмэгтэй 267 эрэгтэй нийт 283 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 43 хүнээр өслөө. Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 52 хэргээр өслөө. Зуунмод суманд 16 эмэгтэй 267 эрэгтэй нийт 288 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 43 хүнээр өслөө.

эмэгтэй 106 эрэгтэй нийт 107 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 54 хүнээр өслөө.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 3 сард кассын орлого 158955.0 сая ₮, кассын зарлага 159143.5 сая ₮ болж, гүйлгээнд 1321.4 сая ₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 3 сарын 31-ний байдлаар 97146.8 сая ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 6047.0 сая ₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 28004.3 сая ₮-ийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 3 сарын 31-ний байдлаар 33972.6 сая ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 3 сарын 31-ны байдлаар 168430 иргэний 4086.1 сая ₮ боллоо.


ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.19-1.34 хувь, хугацаатай доод хүү 0.62-0.65 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0.60-0.62 хувьтай байна.

Арилжааны даатгал эрхлэн явуулдаг байгууллагууд 2014 оны эхний 1 улиралд 1699 даатгуулагчийг хамруулан 43.7 сая ₮-ийн даатгалын хураамж хуримтлуулж, 19.5 сая ₮-ийн нөхөн төлбөр олгожээ.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2014 оны эхний 3 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 2154.5 сая, зарлага 13140.9 сая ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 125.18 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Хувь хүний орлогын албан татвар, бууны албан татвар, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.



Аймгийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 21.4 хувь буюу 380.1 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 85.75 хувийг татварын, 12.81 хувийг татварын бус, 1.44 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2013 оны мөн үеэс татварын орлого 1.79 нэгжээр өсч, татварын бус орлого 1.99 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.22 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 2633.5 сая ₮ болж аймгийнх 1843.7 сая ₮ буюу 70.0 хувь, сумынх 310.8 сая ₮ буюу 11.8 хувь, улсынх 479.0 сая ₮ буюу 18.2 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 57.6 хувь буюу 233.9 сая ₮-өөр өсч 639.9 сая ₮,

авлага 14.4 хувь буюу 22.1 сая ₮-өөр буурч 85.4 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 2138.6 сая ₮ болж, төлөвлөгөө 135.21 хувиар биелэгдлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 310.8 сая ₮ болж, төлөвлөгөө 225.39 хувь биелж, Жаргалант, Баян-Өнжүүл, Угтаал сум 25.4-0.5 хувиар тасалдууллаа.


Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 1843.6 сая ₮ болж 116.45 хувь биелж, Алтанбулаг, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянхангай, Баянцагаан, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт сумд 88.6-2.5 хувиар тасалдууллаа.



III.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 3 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 43,51%, өмнөх оны мөн үеэс 13,06%, өмнөх сараас 1,23 хувиар тус тус өсөв. 3 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 5,89%, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5,09%, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 3,84%, сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 2,52%, саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ 1,89%, төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ 1,68% -аар тус тус өсөв.

Зураг II.4 Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 3 дугаар сарын 1,23 хувийн өсөлтийн 0,62 нэгж (50,2%) нь хүнсний барааны бүлгийн үнийн өсөлтөөс; 0,5 нэгж (40,8%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,04 нэгж (3,05%) нь амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн; 0,03 нэгж (2,3%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,02 нэгж (1,4%) нь эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн; 0,02 нэгж (1,4%) нь бусад бараа үйлчилгээний бүлгийн; 0,01 нэгж (0,7%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнийн өөрчлөлтөөс тус тус шалтгаалсан байна.

Зураг II. 5


Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 3 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	1.23	100.00
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.62	50.17
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.50	40.77
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.01	0.70
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.03	2.30
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	1.41
07. ТЭЭВЭР	0.00	0.00
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.04	3.05
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	1.60



II. Төл бойжилт

4 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 26.39 хувь 422.74 мянган хээлтэгч мал төллөж, 430.86 мянган төл гарсны 99.62 хувь 429.22 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 47.5 хувь буюу 136.18 мянгаар; бойжиж буй төл 51.08 хувь 145.13 мянгаар тус бүр өслөө.



Оны эхний төллөх насны ингэний 5.09; гүүний 3.05; үнээний 10.60; эм хонины 28.25; эм ямааны 29.97 хувь нь тус бүр төллөв. Гарсан төлийн 0.38 хувь 1643 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 1.2 дахин буюу 2002 төлөөр буурлаа. Гарсан унаганы 1.19, тугалын 0.73, хурганы 0.24, ишигний 0.55 хувь нь тус бүр хорогдов.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	МЯН.ТОЛ				
	2010	2011	2012	2013	2014
Бүгд	240.00	278.78	343.36	284.09	429.22
Тэмээ	0.03	0.03	0.11	0.08	2.65
Адуу	2.78	0.42	3.87	1.23	10.29
Үхэр	5.50	2.90	7.78	5.22	0.05
Хонь	145.11	159.99	189.80	166.01	243.78
Ямаа	86.59	115.45	141.80	111.55	172.44

Том малын зүй бус хорогдол

2014 оны 4 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.13 хувь буюу 4569

том мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 1.48 дахин буюу 6782 толгойгоор буурлаа.



Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр, аймгийн дүнгээр жил бүрийн эхний улиралд, мян толгой

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	344165	5409	5268	11351	4569
Тэмээ	25		1	1	2
Адуу	16377	482	520	585	439
Үхэр	16979	486	435	764	382
Хонь	141513	2216	2002	4550	1873
Ямаа	169271	2225	2310	5451	1873



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 3 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 1452.1 сая ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 16.8 хувь буюу 208.9 сая ₮-өөр өслөө.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцагаан, Баянцогт, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Өндөрширээт, Баянчандмань

сумд 48.6-2.07 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 86.92) хувийг эзлэв.


Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 III	2014 III	2013 I-III	2014 I-III	Дүнд залгах % Percentage share to total		2014% 2013%
					2013 I-III	2014 I-III	
Нийт дүн	507.65	853.75	1,243.16	1,452.07	100.0	100.0	116.8%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	5.25	192.70	20.00	198.71	1.61%	13.68	993.6%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	159.67	398.25	305.60	543.34	24.58	37.42	177.8%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	342.73	262.80	917.56	710.02	73.8	48.90	77.4%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 1398.1-12.5 хувь буюу 178.71-4.09 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 3 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 48.9, боловсруулах үйлдвэрлэл 37.4, уул уурхайн үйлдвэрлэл 13.7 хувийг тус тус эзлэв.


Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 3 сард 204,6 сая ₮-ийн их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 7,53 хувиар буюу 16,7 сая ₮-өөр буурав. Их засварын ажлын гүйцэтгэлийн 97,8 хувь нь орон сууцны бус барилгад, 2,2 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдлоо. Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 1 хүнээр, цалингийн сан 6,7 сая ₮-өөр тус тус буурав. Зураг II.8


Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



II.7 Тээвэр, холбоо


Холбоо ашиглалтын орлого оны эхний 3 сард 58.0 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 23.9 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 2.8 дахин буюу 20.8 сая ₮-өөр өслөө.



Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 21.2 сая ₮ болж, нийт орлогын 79.4 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 25.9 хувийг албан бичгийн, 20.4 хувийг зорчигчдийн, 53.7 хувийг бусад орлого эзлэв


2014 оны эхний 3 сард авто тээврээр үйлчилгээ хийдэг компани, хоршоо, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд 1440.5 мянган-тонн ачаа, 15013.9 мянган тонн-км ын ачаа эргэлт, 1104.7 мян-хүнд үйлчлэн 14386.8 мян-хүн-км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 823.6 мянган-тонноор, ачаа эргэлт 2059 мян-тн-км_ээр өслөө. Зорчигч эргэлт 1170.9 мян-хүн-км_ээр буурлаа. Үйлчилсэн хүний тоо 273.4 мянган хүнээр нэмэгдлээ.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 3 сарын

мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 785 гүйцэтгэх хуудсанд нийт 1435.5 сая ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 9 гүйцэтгэх хуудсанд ногдох 30.7 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 776 гүйцэтгэх хуудасны 1404.7 сая ₮-өөс 106 хуудасны 118.6 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 13.66 хувь, үнийн дүнгээр 8.44 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудсны биелэлт 4.22 нэгжээр буурч, үнийн дүнгийн биелэлт 0.50 нэгжээр өслөө.



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 3 сард нийт 2058 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 10.6 сая ₮-ийн орлого орууллаа. Нийт орлогын 43.9 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 24.3 хувийг зээлийн барьцаанаас, 6.2 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 5.8 хувийг худалдааны үйлчилгээнээс, 3.9 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ.

Мал эмнэлэг

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2014 оны эхний 3 сард 320.1 мянган толгой мал хамрагдсан нь 2013 оны

мөн үеэс 13.2 хувь буюу 17.5 мянган толгойгоор нэмэгдлээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ халдварт өвчнийнх 1.35 хувь, ариутгал халдваргүйтэлийнх 26.78 хувийн гүйцэтгэлтэй биелэгдлээ.

Аудит

Аймгийн аудитын газар 2014 оны эхний 3 сард 192 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 168 нь зөрчилгүй, 16 нь хязгаарлалттай, 8 нь санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтүүдтэй гарлаа. Аудитын үйлчилгээний төлбөр 63.2 сая ₮ оруулахаас, орон нутгийн төсөвт 51.9 сая ₮-ийг орууллаа.

Тайлангийн хугацаанд 222.7 сая ₮-ийн 124 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 2.0 сая ₮-ийн 7-г барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 5.6, үнийн дүнгээр 0.9 хувьтай гарлаа.